



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын нэр: “Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг, Засгийн газраас олгосон векселийн үр дүн” гүйцэтгэлийн аудит

ҮАГ- ГАГ/2017/02-ГА-ХөААГ, ҮАГ- ГАГ/2017/04-ГА-ХөААГ

УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

***Зураг, төсөвгүй
төсөл, арга хэмжээг
баталсаар байна.***

**Хөвсгөл аймаг
Мөрөн хот 2017**



Их-Уул сумын СДЭ-ийн автомашин. Төсөвт өртөг 29.0 сая



Цагаан-Үүр сумын цагдаагийн кабоны барилга.



Ахмад настан, ХБИХТ-ийн засвар, тохижилт.
Төсөвт өртөг 35.0 сая төгрөг.



Мөрөн сумын 6-р цэцэрлэгийн их засвар.
Төсөвт өртөг 120.0 сая төгрөг

АГУУЛГА

 Тайланг бэлтгэсэн: Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын газар Тэргүүлэх аудитор Г.Оюунгэрэл Аудитын менежер Г.Эрдэнэчимэг Аудитор Ж.Отгончимэг Шинжээч Б.Сандуйжав 2017 оны 04 дүгээр сар Уг тайланг УАГ-ын Веб сайт-аас үзнэ үү. www.audit.mn Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70384043 дугаарын утас, 70383793 дугаарын факсаар харилцана уу? ХАЯГ: (Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын А байр 3 давхарт)	Товчилсон үгийн тайлбар	3
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4
	Ерөнхий зүйл	6
	БҮЛЭГ-1. Зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээг баталсаар байна.	8
	1.1. Зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээ хөрөнгө оруулалтын төсөвт тусгагдсан байна.	8
	1.2. Зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээг баталсаар байна.	9
	Дүгнэлт.....	10
	Зөвлөмж.....	10
	БҮЛЭГ-2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулсан байна.	11
	2.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулсан хэдий ч хуулийн 49 дүгээр зүйлийн 49,2 дахь заалтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.	11
	Дүгнэлт.....	14
	Зөвлөмж.....	14
	БҮЛЭГ-3. Зарим төсөл, арга хэмжээний магадлашгүй ажлын зардлыг актаар баталгаажуулаагүй олгосон байна.	15
	3.1. Зарим төсөл, арга хэмжээний магадлашгүй ажлын зардлыг актаар баталгаажуулаагүй олгосон байна.	15
	3.2. Гэрээний хугацаа хэтрүүлсний алдангийг тооцоогүй байна.	17
	Дүгнэлт.....	19
	Зөвлөмж.....	19
	БҮЛЭГ-4. Векселиэр санхүүжүүлсэн ТАХ-ээс орон нутагт эрх шилжээгүй байна.	20
	Ерөнхий дүгнэлт	21
	Ерөнхий зөвлөмж	21
	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал	22
	Хавсралт	24
	Зөрчлийн жагсаалт.....	26
	Тэргүүлэх аудиторовн тушаал	27

Товчилсон үгийн тайлбар

Товчилсон үг	Тайлбар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ҮАГ	Үндэсний аудитын газар
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ХөААГ	Хөвсгөл аймгийн аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТХОСЖ	Төсвийн хөрөнгө оруулалтын, санхүүжилтын журам
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
СДЭ	Сум дундын эмнэлэг
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт

Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх.
- Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкнаас 2016 онд санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх.
- Векселиэр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх.

Аудитын хамрах хүрээ

Аудитаар орон нутагт эрх шилжүүлсэн улсын төсөв, улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкны эх үүсвэр, векселиэр болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн ИТХ, ЗДТГ-ын ХБХ, СТСХ, ОНӨГ, ГХБХБГ, сумдын ИТХ болон ЗДТГ, холбогдох байгууллагууд, зарим гүйцэтгэгч ААН-ийн хүрээнд шалгалаа.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын журмыг мөрдөж, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, холбогдох асуудлаар аудитад хамрагдсан байгууллагаас тайлбар, асуулга авах, судалгаанд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулан ажиллалаа.

Шалгуур үзүүлэлтүүд

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамжид заасны дагуу аудитын дүн дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашигласан. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

- Барилгын тухай хууль
- Векселийн тухай хууль
- Өрийн удирдлагын тухай хууль
- Сангийн Сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар баталсан ТХОСЖ
- Сангийн Сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан ТБОНӨХБАҮХА ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам.
- Холбогдох бусад хууль, журам, шийдвэр

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Г.Оюунгэрэл удирдан, аудитын менежер Г.Эрдэнэчимэг аудитын арга зүйгээр хангаж, үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ж.Отгончимэг, шинжээч Б.Сандуйжав нар гүйцэтгэв.

Ерөнхий зүйл:

УТ: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих нийт 11¹ төсөл, арга хэмжээний эрх орон нутагт шилжиж ирсэн байна. Эдгээрээс 1 төсөл, арга хэмжээ нь өмнөх оноос дамжин хэрэгжих, 10 нь шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ байна.

Өмнөх оноос дамжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь хэрэгжиж дууссан, тайлант онд үлдэгдэл санхүүжилт батлагдсан байна. Уг төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжигдэхээр тусгагдсан² байна.

Векселиэр төлбөр гүйцэтгэсэн төсөл арга хэмжээнээс орон нутагт эрх шилжээгүй байна.

ОНТ: Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 19 төсөл, арга хэмжээг 334.13 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр, аймгийн замын сангийн хөрөнгөөр нийт 13 төсөл, арга хэмжээг 495.05 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тус тус баталсан³ байна. Эдгээр төсөл, арга хэмжээг ангилж хүснэгт болон зураглалаар харуулбал:

Хүснэгт 1: ТАХ-ний ангилал

Зураглал 1:

№	ТАХ-ний ангилал	Тоо	Тайлбар
Орон нутгийн хөрөнгө оруулалт			
1	Тайланд онд шинээр хэрэгжүүлсэн.	9	1 ТАХ хэрэгжээгүй /Хүүхдийн эмнэлэг барих ажилд аймгаас үзүүлэх дэмжлэг/
2	Өмнөх онд хэрэгжсэн, тайлант онд үлдэгдэл санхүүжилт батлагдсан.	10	Төлөвлөлт, ХАА, гүйцэтгэлийн талаар өмнөх аудитад тусгагдсан ба үр дүн нь хангалтгүй байгаа ТАХ-г тайлангийн Бүлэг-3-т тайлагнасан.
Аймгийн замын сан			
1	Тайланд онд шинээр хэрэгжүүлсэн.	6	
2	Өмнөх онд хэрэгжсэн, тайлант онд үлдэгдэл санхүүжилт батлагдсан.	7	Төлөвлөлт, ХАА, гүйцэтгэлийн талаар өмнөх аудитад тусгагдсан ба үр дүн нь хангалтгүй байгаа ТАХ-г тайлангийн Бүлэг-3-т тайлагнасан.
	Нийт	32	



Худалдан авах ажиллагааны тухайд:

Хөвсгөл аймгийн Засаг даргын дэргэдэх Худалдан авах ажиллагааны алба нь 2016 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг эх үүсвэр, байгууллага, сумд тус бүрээр нь төлөвлөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын

¹ 10 төсөл, арга хэмжээний ХАА-ны, 7 төсөл, арга хэмжээний санхүүжилтын эрхийг орон нутагт шилжүүлсэн байна.

² Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар хавсралт

³ Аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит 13 дугаар хуралдааны 03 дугаар тогтоол, аймгийн ИТХ-ын 2016 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн ээлжит бус 14 дүгээр хуралдааны 01 дүгээр тогтоол.

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит XIII дугаар хуралдаанд оруулан батлуулсан байна. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн ээлжит бус XIV дүгээр хуралдаанаар тус албаны 2016 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тодотгол хийж зарим нэгэн арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааг нэмж зохион байгуулахаар болсон байна.

Засгийн газрын 2016 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 09 дүгээр тогтоол, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 65 дугаар тогтоолыг үндэслэн Хөвсгөл аймгийн Засаг даргын дэргэдэх Худалдан авах ажиллагааны алба, аймгийн Орон нутгийн өмчийн албыг нэгтгэн Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газар болгон өөрчлөн байгуулсан байна⁴. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэхээр⁵ үйл ажиллагааны үндсэн чиглэлийг нь тодорхойлсон байна.

Сангийн яамны⁶ зүгээс аймгийн Худалдан авах үйл ажиллагааны 2016 оны хэрэгжилтэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49.7 дахь хэсэгт заасныг үндэслэн Хөвсгөл аймгийн Засаг даргын багцын худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг тайлагнах журам /цаашид журам гэх/-ын дагуу үнэлгээ хийж 84,5 оноо буюу “Сайн” гэж үнэлсэн байна.

⁴ Аймгийн Засаг даргын 2016 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А/441 дүгээр захирамж

⁵ Хуулийн этгээдийн 000127618 Улсын бүртгэлийн гэрчилгээ

⁶ МУ-ын Сангийн сайдын 2017 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн 6-1/1346 албат тоот

Бүлэг 1: Зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээг баталсаар байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээ хөрөнгө оруулалтын төсөвт тусгагдсан байна.

1.1. Орон нутагт эрх шилжсэн төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн байгаль орчны мастер төлөвлөгөө, үндсэн чиглэлтэй уялдсан байна.

1.2. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 20,0 хувь нь барилга байгууламж, 40,0 хувь нь их засвар, 40,0 хувь нь машин, тоног төхөөрөмж байна.



1.3 Зарим нэгэн төсөл, арга хэмжээний зураг, төсөв нь хийгдээгүйгээр хөрөнгө оруулалтын төсөвт тусгагдсан байна. Тухайлбал:

- Мөрөн сумын “Гурван гал” ӨЭМТ-ийн их засвар, өргөтгөл /2016 онд зураг, төсөв нь хийгдсэн, 2016.09.25-нд хянан баталгаа хийгдсэн/
- Мөрөн сумын 6 дугаар цэцэрлэгийн их засвар /2016 онд зураг, төсөв нь хийгдсэн, 2016.03.28-нд хянан баталгаа хийгдсэн/

- Мөрөн сумын 4 дүгээр цэцэрлэгийн их засвар /2016 онд зураг, төсөв нь хийгдсэн, 2016.05.03-нд хянан баталгаа хийгдсэн/

- Мөрөн сумын 7 дугаар цэцэрлэгийн их засвар /2016 онд зураг, төсөв нь хийгдсэн/

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29.4⁷ дэх заалтыг зөрчсөн байна. Өмнөх аудитаар уг зөрчлийг арилгах зөвлөмжийг аймгийн Засаг даргад өгсөн хэдий ч биелүүлээгүй байна.

1.4 Алаг-Эрдэнэ, Цагаан-Үүр сумдын цагдаагийн кабоны барилгын ажлын худалдан авах ажиллагааны эрхийг аймгийн Цагдаагийн газарт шилжүүлсэн бөгөөд холбогдох баримт материалыг ЦЕГ-т хүргүүлсэн тул зураг, төсөв нь хөрөнгө оруулалтын төсөв батлагдахаас өмнө хийгдсэн эсэхийг тодруулах боломжгүй байна.

1.5 Төсөл, арга хэмжээний зураг, төсвийг хөрөнгө оруулалтын төсөв батлагдахаас өмнө хийгээгүй нь: Төлөвлөлттэй холбоотой хүний болон санхүүгийн нөөцөө үр ашигтай ашиглаж чадаагүйтэй холбоотой байна. Үүний улмаас төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа хэрэгжихгүй байх нөхцөл байдал үүсч байна. Тухайлбал:

Мөрөн сумын “Гурван гал” ӨЭМТ-ийн их засвар, өргөтгөлийн ажил он дамжин /Ажил гүйцэтгэх гэрээг 2017.06.20 хүртэл сунгасан/ хэрэгжихээр болсон байна.

1.6 Төлөвлөлттэй холбоотой бусад асуудлыг орон нутгаас тодруулах боломжгүй байна.

⁷ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

Зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээг баталсаар байна.

1.7 Орон нутгийн хөрөнгө оруулалт, замын сангийн хөрөнгөөр тайлант онд шинээр хэрэгжүүлсэн 15 төсөл, арга хэмжээнээс 4⁸ нь аймгийн 2012-2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2014-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн байгаль орчны мастер төлөвлөгөө, Хөвсгөл аймгийн эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг баримт, бичигт тусгасан зорилт, арга хэмжээтэй уялдаагүй байна.

1.8 Бодлогын баримт бичигт тусгагдаагүй төсөл, арга хэмжээнүүд нь хэрэгцээ шаардлагад үндэслэн аймгийн төсвийн тодотголоор батлагдсан байна.

1.9 Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 40,0 хувь нь зам, давааны засвар, 33,3 хувь нь их засвар, 26,7 хувь нь тоног төхөөрөмж байна.

1.10 Өмнөх оноос дамжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтыг батлахдаа нөөцийг бодитой хуваарилсан байна. Эдгээр төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нь үндэслэлгүйгээр нэмэгдээгүй батлагдсан хэдий ч төсөл, арга хэмжээний эхлэх, дуусах хугацаа өмнөх оны тогтоолуудаас зөрүүтэй баталсан байна. Энэ нь тайлант онд үлдэгдэл санхүүжилтыг олгохоор шийдвэрлэсэнтэй холбоотой байна.

1.11 Зарим төсөл, арга хэмжээний зураг, төсөв нь аймгийн ИТХ-ын хуралдаанаар баталснаас хойш хийгдсэн байна⁹. Үүний улмаас зарим төсөл, арга хэмжээний хянан баталгаа хийсэн төсөвт өртөг аймгийн ИТХ-ын хуралдаанаар буурч батлагдсан байна. Өмнөх оны аудитаар уг зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн ч биелүүлээгүй байна. Дээрх зөрчилтэй төсөл, арга хэмжээг дурьдвал:



- Бүрэнтогтох, Төмөрбулаг сумдын чиглэлийн Цагаанбургасын давааны зам засварын ажил /2016 онд зураг, төсөв нь хийгдсэн, 2016.04.28-нд хянан баталгаа хийгдсэн/
- Түнэл, Чандмань-Өндөр сумдын чиглэлийн Бор бургасын давааны зам засварын ажил /2016 онд зураг нь хийгдсэн, 2016.01.28-нд зураг, төсөвт хянан баталгаа хийгдсэн. Төсөвт өртөг 102.3 сая төгрөг, аймгийн ИТХ-ын хуралдаанаар баталсан төсөвт өртөг 90.0 сая төгрөг/
- Цагаан-Үүр сумын Тарвагатайн давааны зам засварын ажил /2016 онд төсөв нь хийгдсэн, 2016.03.31-нд зураг, төсөвт хянан баталгаа хийгдсэн/
- Эрчим-1 ахмадын амралтын газрын 5 байрны дээврийн засварын ажил /2016 онд зураг, төсөв нь хийгдсэн, 2016.06.02-нд хянан баталгаа хийгдсэн/

1.12 Мөрөн сумын Сод-Эрдэм сургуулийн баруун талын 0.4 км хайрган хучилттай авто замын ажлын тухайд: Аймгийн ИТХ-ын хуралдаанаар “Замын сангийн нөөц хөрөнгө” гэж батлагдсан арга хэмжээний хүрээнд хийгдсэн бөгөөд зураг, төсөв нь тухайн үед хийгдсэн байна.

⁸ МСҮТ-ийн дотуур байрны агааржуулагчийн засвар, Зам талбай арга хэмжээ, Батсуурь багшийн хөшөө дурсгалыг сэргээх ажил, Цагаан-Үүр сумын эхчүүдийн амрах байрны тохижилт /Сүүлийн 3 төсөл, арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх байдлаар баталсан/

⁹ Төсвийн тухай хуулийн 29.4, Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журмын 5-г тус тус зөрчсөн.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Орон нутагт эрх шилжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний зураг, төсөв хийгдээгүй байхад хөрөнгө оруулалтын төсөвт тусгасан, зураг, төсөв хийгдээгүй төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-ын хуралдааны тогтоолоор баталсан байна.
2. Уг зөрчлийг арилгах зөвлөмжийг өмнөх аудитаар өгсөн ч биелүүлээгүй, хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй холбоотой хүний болон санхүүгийн нөөцөө үр ашигтай ашиглаж чадаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Л.Төмөрбаатар-т:

1. ТЭЗҮ, зураг, төсөв хийгдээгүй төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэхгүй, батлахгүй байх.

Аймгийн Засаг дарга Л.Ганболд-д:

1. Зураг, төсөв нь хийгдсэн төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөвт тусгуулах, аймгийн ИТХ-ын хуралдаанд өргөн мэдүүлж батлуулах.
2. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 заалтыг зөрчин зураг төсөв нь батлагдаагүй төсөл арга, хэмжээг төлөвлөсөн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцон ажиллаж, төлөвлөлттэй холбоотой хүний болон санхүүгийн нөөцөө үр ашигтай ашиглах.

Бүлэг 2: Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулсан байна.

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулсан хэдий ч хуулийн 49 дүгээр зүйлийн 49,2 дахь заалтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

2.1. Хөвсгөл аймгийн Худалдан авах ажиллагаа, орон нутгийн өмчийн газар нь 2016 онд улсын төсвөөр хийгдэх /эрх шилжсэн төсөл арга хэмжээ/ 10 ТАХ, замын сангийн хөрөнгөөр хийгдэх 6 ТАХ, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх 8 ТАХ-ний худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан байна. Хавсралт 1-ээс харна уу. Аймгийн Засаг дарга /захиалагч/ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах¹⁰ тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1.1, Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаал, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн худалдан авалт зохион байгуулах тухай бүр “Үнэлгээний хороо”-г байгуулан ажилласан байна.

2.2. Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан “Үнэлгээний хороо”- нь хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байна. Худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг өмнөх онтой харьцуулж хүснэгтээр харуулбал: /тоогоор/

Хүснэгт 2: Худалдан авах ажиллагааг өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт

№	Эх үүсвэр	Нээлттэй тендер шалгаруулалт		Харьцуулалтын арга		Шууд худалдан авалт	
		2015	2016	2015	2016	2015	2016
1	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	12	5	1	5		
2	Орон нутгийн хөрөнгө оруулалт		1	3	4	3	1
3	Замын сангийн хөрөнгө	1	2	10	3	2	
4	Нийт	13	8	14	12	5	1

2.3. Тайлант онд ихэнх худалдан авах үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулсан байна. Цахим хэлбэрээр зохион байгуулсан “тендер”-т нэг компани оролцож тэр нь шалгарч эсвэл нэг ч оролцогч үнийн санал ирүүлэхгүй шууд гэрээ байгуулах аргыг хэрэглэсэн тохиолдлууд гарч байгаа нь төсвийг бага дүнгээр хэт жижиглэж баталсантай холбоотой байна. Энэ нь хуулийн дагуу хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулсан эсэхэд харьцуулалт хийх боломжгүй байдал үүсгэж байна.

2.4. Тухайн байгуулагдсан “Үнэлгээний хороо”- нь тендерийн баримт бичгийн төслийг боловсруулан захиалагчаар батлуулж, баталгаажсан хувийг тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч хуулийн этгээдэд тарааж, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Босго үнэ батлах тухай”, Сангийн сайдын 2013 оны 84 дүгээр

¹⁰ Цаашид хуулийн гэх

тушаалаар баталсан “Цахим сүлжээнд, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам”-ыг тус тус баримтлан тендер шалгаруулалтын зар, үр дүнг худалдан авах ажиллагааны цахим хуудас /www.e-procurement.mn/-нд байршуулж, мэдээлж ажилласан байна. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа холбогдох хууль болон журмын дагуу ажилласан бөгөөд ХАА-ны журмыг зөрчсөн асуудал байхгүй байна.¹¹

2.5. Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар буюу эрх шилжсэн 10 ТАХ, орон нутгийн өмчийн хөрөнгөөр 8 ТАХ, аймгийн замын сангийн хөрөнгөөр 6 ТАХ -ний худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд хуулинд заасан хугацаанд худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан байна.

2.6. Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын тайланг Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу тайлагнасан хэдий ч журмын маягт 2-/гуравын 3.2/-т Гэрээний хэрэгжилтэд хэрхэн хяналт тавьж ажилласан талаарх мэдээллийг тусгана гэж заасныг хангалтгүй тайлагнасан байна. Учир нь: Засаг даргын захирамжаар байгуулагдсан “Төслийн баг”-ийн дарга нар хийсэн ажлын баримтыг нэгтгэн архивын нэгж болгон худалдан авах ажиллагаанд өгдөггүй, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах эрх бүхий ажилтан хангалтгүй ажилласантай холбоотой гэж гүйцэтгэлийн аудитаар үзэж байна.

2.7. Хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь заалтыг хангалтгүй хэрэгжүүлж ажилласан байна. Тус газрын Тендерийн хавтаст хэрэгтэй танилцахад хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.10-д заасан (...гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг...) бүрдүүлэлт туйлын хангалтгүй байна. Энэ нь тухайн ажлыг хариуцсан төрийн албан хаагчдын ажлын уялдаа холбоо хангалтгүй байгаатай холбоотой байна.

2.8. Зарим нэгэн ТАХ-ний худалдан авах үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулсан хэдий ч “Гэрээ”-г холбогдох яамдууд дээр хийснээр гэрээний гүйцэтгэлд тавих хяналт орхигдсон зөрчил байна. Тухайлбал: Хөвсгөл аймгийн Жаргалант сумын эрүүл мэндийн төвд нийлүүлэх автомашин, Их-Уул, Түнэл сумдын ойжуулалтын ажил зэргийг дурьдаж болох юм.

2.9. Худалдан авах ажиллагаанаас бий болсон хэмнэлтийг Орон нутгийг өмчийн газар зарцуулдаггүй байна. Харин Төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрхийн хүрээнд төсвийн дахин хуваарилалтаар батлагдан зарцуулагддаг байна. Тендерийн хэмнэлтийг эх үүсвэр тус бүрээр нь хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3: Тендерийн хэмнэлт /сая төгрөг/

№	Эх үүсвэр	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендерийн хэмнэлт	Тендерийн тоо
1	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	932,4	838,9	93,5	10
2	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	164,4	154,8	9,6	6
3	Замын сангийн хөрөнгө	353,3	325,7	27,5	5
4	Нийт дүн	1450,0	1319,4	130,6	21

Хүснэгтээс харвал: Нийт 21 Худалдан авах үйл ажиллагааг батлагдсан төсвөөс 130,6 сая төгрөгийн хэмнэлттэй зохион байгуулсан байна.

¹¹ Хөвсгөл аймгийн Жаргалант сумын эрүүл мэндийн төвд автомашин нийлүүлэх болон Их-Уул, Түнэл сумдад ойжуулалт хийх ажлын гүйцэтгэгчийг хэрхэн сонгон шалгаруулсан тухай тайлбар бичиг авсан.

2.9. Төсвийн ерөнхийлөн захирагчдаас ХАА-ны эрхийг шилжүүлэхдээ ХАА-ны төлөвлөгөө батлагдсанаас хойш болон хүйтний улирал эхэлсэн үед шилжүүлэгдэж байгаас худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулахад хугацаа алдаж, хүндрэл учирч байна. Тухайлбал:

Хүснэгт 4: Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт

№	Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр	Тушаалын огноо дугаар	Төсөл арга хэмжээний нэр
1	МУ-ын Эрүүл мэндийн сайд	2016.09.15/A/48	Мөрөн сумын Гурван гал өрхийн эмнэлгийн их засварын ажил
2	МУ-ын БСШУССайд	2016.10.20/A/81	Мөрөн сумын 7 дугаар цэцэрлэгийн барилгын бохир усыг нэгдсэн шугаманд холбох

Дээрх хүснэгтээс харвал: Мөрөн сумын Гурван гал өрхийн эмнэлгийн их засвар, Мөрөн сумын 7 дугаар цэцэрлэгийн барилгын бохир усыг нэгдсэн шугаманд холбох зэрэг ажлуудыг 2016 оны 9 дүгээр сарын 15-наас 10 дугаар сарын 20-ны хооронд эрх шилжүүлсэн байна.

2.10. Энэхүү хугацаанаас харахад худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангахад хүндрэлтэй, хууль зөрчих асуудал гарсныг “Үнэлгээний хороо”-ны хурлын тэмдэглэлээс (...ГХБХБГ-ын барилгын хэлтсийн дарга Б.Энхжаргал: Зураг, төслийн хүрээнд яаралтай ХАА-г зохион байгуулах хэрэгтэй Учир нь “Гурван гал” өрхийн эмнэлэгийн барилгын их засварын ажил нь цаг хугацааны хувьд, өвлийн улиралд явагдах тул хуулийн хугацаанд гүйцэтгэгчийг шалгаруулж, ажлыг эхлүүлэх нь зүйтэй. Мөн барилгын ажлын гүйцэтгэл барилгын норм, дүрмийн дагуу хөрсөн дээр -5 хэмээс дээш хүйтэрсэн тохиолдолд барилгын ажлыг гүйцэтгэх боломжгүй болдог, уг тендерийг 10 дугаар сарын 24-ний өдөр нээнэ, ээрээ байгуулах цаашлаад ажил эхлэх хүртэл 11 сар гарч хүйтний эрч эрс нэмэгдэх үед барилгын ажил хийгдэх явц харагдаж байгааг захиалагч анхаарах шаардлагатай байгаа...) ¹² харж болох юм.

2.11. Захиалагч байгууллагын саналыг үндэслэн дараагийн хуралдаанаар “Гурван гал” өрхийн эмнэлгийн барилгыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар засварлах ажлыг гүйцэтгэгч сонгох аймгийн Онцгой комисст танилцуулан “Гэрээ шууд байгуулах” аргыг хэрэглэх талаар шийдвэрлэсэн байна.¹³ Онцгой комиссын хуралдаанаар уг асуудлыг хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5¹⁴ дахь хэсэгт заасны дагуу зохион байгуулахаар шийдвэрлэсэн байна. Гурван гал өрхийн эмнэлэгийн барилгын их засварын ажлын гүйцэтгэгч сонгох гэрээ байгуулах үйл ажиллагаа нь хуулийн 17 дугаар зүйлийн 17.1¹⁵ дэх заалтыг зөрчсөн гэж гүйцэтгэлийн аудитаар үзсэн. Энэхүү зөрчил нь Төсвийн ерөнхийлөн захирагчдаас ХАА-ны эрхийг шилжүүлэхдээ хугацаа алдаж шилжүүлсэнтэй холбоотойгоор үүссэн байна. Энэхүү зөрчил нь барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэгч сонгоход ажиглагдаж байна. Учир нь тухайн ажлуудыг хүйтний улирал эхэлсэн үед гүйцэтгэх боломжгүй, барилгын технологийн горим алдагдах эрсдэлтэй юм.

2.12. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөл, арга хэмжээний зориулалтыг өөрчилсөн асуудал гараагүй байна. Аймгийн ИТХ-ын баталсан 2016 онд бараа ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний нэршил болон зориулалтыг өөрчилсөн асуудал гараагүй байна. Харин БСШУС-аас аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн ТАХ болох Мөрөн сумын 7

¹² Үнэлгээний хорооны 2016 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн №01 хурлын тэмдэглэлээс

¹³ Үнэлгээний хорооны 2016 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн №02 хурлын тэмдэглэлээс

¹⁴ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.1.15. гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас нээлттэй буюу хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмын дагуу тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй бол

¹⁵ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.1 Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана.

дугаар цэцэрлэгийн барилгын бохир усыг нэгдсэн шугамд холбох ажлыг 7 дугаар цэцэрлэгийн дотор шугам сүлжээг засварлах ажил болгон өөрчилсөн зөрчил байна.

2.13. Бид гүйцэтгэлийн аудитын явцад Орон нутгийн өмчийн газарын дарга болон холбогдох ажилтан албан хаагчидтай уулзаж санал солилцож, тайлбар гаргуулан, амаар зөвлөмж өгч ажилласан болно.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа холбогдох хууль болон журмын дагуу ажилласан бөгөөд ХАА-ны журмыг зөрчсөн асуудал байхгүй байна.
2. Хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь заалтыг хангалтгүй хэрэгжүүлж ажилласан байна. Энэ нь тухайн ажлыг хариуцсан төрийн албан хаагчдын ажлын уялдаа холбоо хангалтгүй байгаатай холбоотой байна.
3. Гурван гал өрхийн эмнэлгийн барилгын их засварын ажлын гүйцэтгэгч сонгох, гэрээ байгуулах үйл ажиллагаа нь хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтыг зөрчсөн бөгөөд энэхүү зөрчил нь Төсвийн ерөнхийлөн захирагчдаас ХАА-ны эрхийг шилжүүлэхдээ хугацаа алдаж шилжүүлсэнтэй холбоотойгоор үүссэн байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Л.Ганболд-д:

1. “Төслийн баг” байгуулсан захирамжийнхаа хэрэгжилтийг хангуулж ажиллах.
2. Тухайн ажлыг хариуцсан төрийн албан хаагчдын ажлын уялдаа холбоог сайжруулж ажиллах.

Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Болд-д:

1. Хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах, “Төслийн баг” байгуулсан Засаг даргын захирамжид хяналт тавьж ажиллах.
2. Тендерийн бичиг баримтыг холбогдох хууль, дүрэм журмын дагуу үдэж цэгцлэн архивын нэгж болгох.

Бүлэг 3: Зарим төсөл, арга хэмжээний магадлашгүй ажлын зардлыг актаар баталгаажуулаагүй олгосон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Зарим төсөл, арга хэмжээний магадлашгүй ажлын зардлыг актаар баталгаажуулаагүй олгосон байна.

3.1. Тайлант онд хэрэгжиж байгаа 11 төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээллийг Хавсралт 2-оос харна уу. Эдгээр төсөл, арга хэмжээний хэрэгжилт 90.9 хувьтай байна. Зарим төсөл, арга хэмжээ нь дотроо төсөл, арга хэмжээнүүдэд хуваагдсан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5: Төсөл, арга хэмжээний эрх шилжсэн байдал

№	Төсөл, арга хэмжээ	Хуваагдсан ТАХ-ний нэр	ХАА-ны эрх шилжсэн	Санхүүжилтын эрх шилжсэн
1	Цагдаагийн кабон /Хөвсгөл Алаг-Эрдэнэ сум/		тийм	
2	Цагдаагийн кабон /Хөвсгөл Цагаан-Үүр сум/		тийм	
3	"Гурван гал" өрхийн эмнэлгийн их засвар /Хөвсгөл, Мөрөн/		тийм	тийм
4	Цэцэрлэгийн барилгын засвар /Хөвсгөл, Мөрөн сум, 6 дугаар цэцэрлэг/		тийм	тийм
5	Цэцэрлэгийн барилгын засвар /Хөвсгөл, Мөрөн сум, 7 дугаар цэцэрлэг/		тийм	тийм
6	Цэцэрлэгийн засвар /Хөвсгөл, Мөрөн сум, 4 дүгээр цэцэрлэг/		тийм	тийм
7	Жаргалант сумын ЭМТ-д түргэн тусламжийн автомашин нийлүүлэх		тийм	
8	Их-Уул сумын СДЭ-т түргэн тусламжийн автомашин нийлүүлэх		тийм	тийм
9	Агаар дахь тоосонцорыг хэмжих багаж хэрэгсэл, бусад тоноглол нийлүүлэх		тийм	
10	Тоног төхөөрөмж нийлүүлэх	- Мөрөн сумын БХТ-н сантехникийн засвар - Мөрөн сумын ЗДТГ-т тоног төхөөрөмж нийлүүлэх - Мөрөн сумын ЗДТГ-т автомашин нийлүүлэх - Арбулаг сумын багийн соёлын төвийн засвар	тийм	Тийм /Мөрөн сумын ЗДТГ-т тоног төхөөрөмж, автомашин нийлүүлэх арга хэмжээний / тийм
11	Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4 кв-н өргөтгөл, шинэчлэл	- Зүүн Мөрөн хорооллын цахилгаан хангамж - Мөрөн сумын 10-р багийн 0.4 кв-ын шугамын ажил		

Хүснэгтээс харахад: “Тоног төхөөрөмж нийлүүлэх” төсөл, арга хэмжээний хүрээнд 2 засварын ажил хийгдсэн байна. Энэ нь ТХОСЖ-ын 3.25¹⁶-г зөрчсөн байна. Эдгээр төсөл, арга хэмжээний санхүүжилтын эрх орон нутагт шилжээгүйгээс санхүүжилт болон гүйцэтгэлтэй холбоотой баримт, материал холбогдох хэлтэс, газарт байхгүй байна. /Бусад санхүүжилтын эрх шилжээгүй төсөл, арга хэмжээ адил байна/

Дээрх зөрчлийг Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад “Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцын тоног төхөөрөмж ажлын

¹⁶ Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлын хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно.

үлдэгдэл, аймаг, сумдад хийгдэх их засвар” гэж залруулан ЗГХЭГ-ын даргын 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 55 дугаар тушаалаар захиалагчийн эрхийг орон нутагт шилжүүлсэн байна.

3.2. Тайлант онд хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээнүүдийг улсын комисс хүлээж авсан бөгөөд гүйцэтгэгчид санхүүжилт олгохдоо холбогдох зардлуудыг /барьцаа хөрөнгө, хяналтын зардал гэх мэт/ тооцон олгосон байна.

3.3. “Тоног төхөөрөмж нийлүүлэх”, “Их-Уул сумын СДЭ-т түргэн тусламжийн автомашин нийлүүлэх” төсөл, арга хэмжээний ажил гүйцэтгэх гэрээг дүгнээгүй, бусад төсөл, арга хэмжээний ажил гүйцэтгэх гэрээг дүгнэсэн байна.

3.4. Зарим төсөл, арга хэмжээний магадлашгүй ажлын зардлыг олгохдоо ТХОСЖ-ын 3.13¹⁷-д заасны дагуу олгоогүй байна. Өмнөх оны аудитаар уг зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн ч биелүүлээгүй байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6: Актаар тогтоогоогүй магадлашгүй ажлын зардал /мянган төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч	Магадлашгүй ажлын зардлын дүн
1	Цэцэрлэгийн барилгын засвар /Хөвсгөл, Мөрөн сум, 6 дугаар цэцэрлэг/	Хөвсгөл мичид ХХК	2010.5
2	Цэцэрлэгийн барилгын засвар /Хөвсгөл, Мөрөн сум, 7 дугаар цэцэрлэг/	Титэмт барилга трейд ХХК	600.4
	Нийт дүн		2610.9

Магадлашгүй ажлын зардлын гүйцэтгэл гарган баталгаажуулсан тул зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.5. Төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, улсын комисс хүлээн авсан ч зөрчил, дутагдалтай барилга байгууламж байна. Үүнд:

- 4-р цэцэрлэгийн барилгын засвар: Гал тогоонд уур гаргагч угсраагүй, бохир усны үнэр гаргагч яндангийн угсралт муу хийгдсэн. /үнэр татахгүй байгаа/
- 7-р цэцэрлэгийн барилгын засвар: Цайрдсан хоолой ф15 28 метр, ф20 16 метр, ган хоолой ф32 86 метр урт, ф25 86 метр урт, ф20 114 метр урт, ф15 150 метр урт байхаар тусгасан байхад Плостмасон хоолой угсарсан, дотор талд үнэр гаргагчууд үнэрээ татахгүй, халаалтын шугамыг угааж цэвэрлэх ба холбох хэрэгслүүдийг солих шаардлагатай байна.

3.6. Бусад төсөл, арга хэмжээний хувьд ашиглалт сайн, ямар нэгэн зөрчил, дутагдалгүй байна. Эдгээр төсөл, арга хэмжээний хувьд захиалагч болон зохиогч хяналт тавьж ажилласанаар ажлын гүйцэтгэл үр дүнтэй болсон байна. Зарим төсөл, арга хэмжээг зургаар харуулбал:

Зураг 1: Улсын төсвийн хөрөнгө оруулалт



Эх сурвалж: Мөрөн сумын 6-р цэцэрлэгийн засвар



Их-Уул сумын СДЭ-ийн автомашин

¹⁷ Төсвийн магадлашгүй ажлын зардлыг захиалагч, гүйцэтгэгч байгууллагын хамтран тогтоосон актын дагуу олгох бөгөөд актаар тогтоогоогүй магадлашгүй ажлыг санхүүжүүлэхгүй.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

Гэрээний хугацаа хэтрүүлсний алдангийг тооцоогүй байна.

3.7. 2016 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний биелэлт 93.3 хувьтай байна. Хэрэгжилтийн ерөнхий мэдээллийг Хавсралт 2-оос харна уу. Хэрэгжиж дууссан ажлуудыг комисс хүлээн авч, ажлын гэрээг дүгнэсэн байна. Зарим төсөл, арга хэмжээний ажлын гэрээг дүгнэхдээ хугацаа хэтрүүлсний алдангийг тооцоогүй байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 7: Хугацаа хэтрүүлсний алданги

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эх үүсвэр	Гүйцэтгэгч	Хугацаа хэтэрсэн хоног	Алданги /мян.төг/
1	МСҮТ-ийн дотуур байрны агааржуулагчийн засвар	Орон нутгийн хөрөнгө оруулалт	Хөвсгөл жугнай ХХК	29	145.0
2	Эрчим-1 ахмадын амралтын газрын 5 байрны дээврийн засвар	Орон нутгийн хөрөнгө оруулалт	Идэр нумт ХХК	8	72.0
3	Цагаан-Үүр сумын Тарвагатайн давааны зам засвар	Замын сан	Хөвсгөл зам ХХК	36	1636.0
4	Архивын тасагт техник хэрэгсэл нийлүүлэх	Орон нутгийн хөрөнгө оруулалт	Гранада ХХК	9	138.1
Нийт дүн					1991.1

Улсын комиссын хурлын тэмдэглэлд нөхцөл, шалтгааныг тусгасан байсан тул зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.8. Тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнд нийт 520.5 сая төгрөгийн санхүүжилт олгохоор гэрээ байгуулснаас 486.74 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Санхүүжүүлээгүй дүн нь: Зарим төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, зохиогчийн хяналт хийгдээгүй, магадлашгүй ажлын зардал гараагүй зэрэгтэй холбоотой байна. Санхүүжилт нь дутуу болон олгогдоогүй төсөл, арга хэмжээний мэдээллийг Хавсралт 2-оос харна уу.

3.9. Өмнөх оноос шилжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнд нийт 226.59 сая төгрөг батлагдсанаас 128.76 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

3.10. Зарим төсөл, арга хэмжээний магадлашгүй ажлын зардлыг олгохдоо ТХОСЖ-ын 3.13-д заасны дагуу олгоогүй байна. Өмнөх оны аудитаар уг зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн ч биелүүлээгүй байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 8: Актаар тогтоогоогүй магадлашгүй ажлын зардал /мянган төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эх үүсвэр	Гүйцэтгэгч	Магадлашгүй ажлын зардлын дүн	Тодруулга
1	Бүрэнтогтох, Төмөрбулаг чиглэлийн Цагаанбургасын давааны зам засвар	Замын сан	Хүслэнт бүтээмж ХХК	2910.0	Магадлашгүй ажлын төсөв хийсэн. Улсын комиссын хурлын тэмдэглэлд тусгагдсан.
2	Цагаан-Үүр сумын Тарвагатайн давааны зам засвар	Замын сан	Хөвсгөл зам ХХК	809.7	Улсын комиссын хурлын тэмдэглэлд тусгагдсан.
3	Гавъяат багш Д.Батсуурийн хөшөө, дурсгалыг сэргээн	Орон нутгийн	Их цэц брэнд ХХК	71.2	Ямар нэгэн санал гаргаагүй.

засварлах	хөрөнгө оруулалт			
Нийт дүн			3790.9	

Магадлашгүй ажил гүйцэтгэсэн талаар улсын комиссын тэмдэглэлд тусгагдсан тул зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.11. Гэрээнд заасан нөхцлийн дагуу гүйцэтгэгч нарт санхүүжилтыг олгохдоо гэрээний үнийн дүнгийн 5 хувиар тооцон чанарын баталгаат хугацааны барьцаа хөрөнгийг “барьцаа хөрөнгө данс”-д байршуулсан байна.

3.12. 2016 онд чанарын баталгаат хугацаа нь дуусч байгаа төсөл, арга хэмжээний барьцаа хөрөнгийг чөлөөлөхдөө Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4¹⁸-д заасны дагуу үзлэг хийж чөлөөлсөн байна. Энэ нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

3.13. Шинээр хэрэгжсэн төсөл арга хэмжээний хувьд ашиглалт сайн, ямар нэгэн зөрчил, дутагдалгүй байна. Эдгээр төсөл, арга хэмжээний хувьд захиалагч болон зохиогч хяналт тавьж ажилласанаар ажлын гүйцэтгэл үр дүнтэй болсон байна. Зургаар харуулбал:

Зураг 2: Орон нутгийн хөрөнгө оруулалт



Эх сурвалж: Архивын тасгийн тоног төхөөрөмж Ахмадын амралтын байрны дээврийн засвар

3.14. Өмнөх оноос шилжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хувьд ашиглалтын шаардлага хангахгүй, үр өгөөжөө өгөөгүй төсөл, арга хэмжээ байна. Дурьдвал:

- Төмөрбулаг сумын халуун усны барилгын өргөтгөл: Уг халуун ус нь одоогийн байдлаар шатсан байна. Энэхүү ажилд 2015 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 42.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. /Уг ажилд тайлант онд 0.66 сая төгрөг батлагдсан/
- Түнэл сумын хүн эмнэлгийн засвар: Уг ажлын хүрээнд 8*10 м-н харьцаатай 1 давхар палкан барилга баригдсан бөгөөд дулаан алдалт ихтэй болсон байна. Одоогийн байдлаар төсөл, арга хэмжээний зориулалт өөрчлөгдөн эмнэлэг бус багийн дарга нар байрласан байна. /Уг ажилд тайлант онд 0.8 сая төгрөг батлагдсан/

¹⁸ Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсон тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийж, зөрчлийг арилгах талаар тэмдэглэл үйлдэнэ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Орон нутагт эрх шилжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтын эрх шилжээгүй төсөл, арга хэмжээний гэрээг дүгнэсэн болон гүйцэтгэлийн баримтгүй байна.
2. Зарим төсөл, арга хэмжээний гэрээний хугацаа хэтрүүлсний алдангийг тооцоогүй, магадлашгүй ажлын зардлыг актаар баталгаажуулаагүй олгосон байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Л.Ганболд-д:

1. Орон нутагт эрх шилжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын бүх төсөл, арга хэмжээний гэрээг дүгнэж, гүйцэтгэлийн баримтыг архивын нэгж болгох.
2. Ажил гүйцэтгэх гэрээний хугацаа хэтрүүлсний алдангийг тооцох, магадлашгүй ажлын зардлыг ТХОСЖ-ын 3.13-д заасны дагуу актаар тогтоон олгож байх.

СТСХ-ийн дарга Сувд-д:

1. Магадлашгүй ажлын зардлыг актаар баталгаажсан тохиолдолд санхүүжилтийг олгож байх.

Бүлэг 4: Векселиэр санхүүжүүлсэн ТАХ-ээс орон нутагт эрх шилжээгүй байна.

Векселиэр санхүүжүүлсэн ТАХ-ээс орон нутагт эрх шилжээгүй байна.

4.1. Хөвсгөл аймагт 2016 онд векселиэр санхүүжүүлэх нийт 19 төсөл, арга хэмжээг баталсан¹⁹ байна. Векселиэр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээнүүд нь өмнөх оноос дамжин хэрэгжиж байгаа */Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байсан төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтыг векселиэр санхүүжүүлсэн/* ба тайлант онд шинээр хэрэгжээгүй байна. Эдгээр төсөл, арга хэмжээний эрх орон нутагт шилжээгүй байна.

¹⁹ Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 4 дүгээр хавсралт
ҮАГ- ГАГ/2017/02-ГА-ХөААГ, ҮАГ- ГАГ/2017/04-ГА-ХөААГ

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Зураг, төсөв нь хийгдээгүй төсөл, арга хэмжээг хууль болон тогтоолоор баталсаар байна. Уг зөрчлийг арилгах зөвлөмжийг биелүүлээгүй, төлөвлөлтийн үеийн хүний, санхүүгийн нөөцөө үр ашигтай ашиглаагүй байна.
2. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь заалтыг хангалтгүй хэрэгжүүлсэн, зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгох, гэрээ байгуулах үйл ажиллагаа нь хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтыг зөрчсөн зэргийг эс тооцвол худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулсан байна.
3. Орон нутагт эрх шилжсэн ч санхүүжилтын эрх шилжээгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн баримт байхгүй, зарим төсөл, арга хэмжээний магадлашгүй ажлын зардлыг актаар тогтоогоогүй олгосон, гэрээний хугацаа хэтрүүлсний алдангийг тооцоогүй байна.

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Л.Төмөрбаатар-т:

1. ТЭЗҮ, зураг, төсөв хийгдээгүй төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэхгүй, батлахгүй байх.

Аймгийн Засаг дарга Л.Ганболд-д:

1. Зураг, төсөв нь хийгдсэн төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөвт тусгуулах, аймгийн ИТХ-ын хуралдаанд өргөн мэдүүлж батлуулах, уг зөрчлийг арилгах зөвлөмжийг биелүүлээгүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцон ажиллаж, төлөвлөлттэй холбоотой хүний болон санхүүгийн нөөцөө үр ашигтай ашиглах.
2. Худалдан авах ажиллагаатай холбоотой гаргасан захирамжийн хэрэгжилтийг хангуулж, тухайн ажлыг хариуцсан төрийн албан хаагчдын ажлын уялдаа холбоог сайжруулах.
3. Орон нутагт эрх шилжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэж, холбогдох баримт, материалыг архивын нэгж болгох, магадлашгүй ажлын зардал, гэрээний хугацаа хэтрүүлсний алдангийг хууль, эрх зүйн дагуу шийдвэрлэх.

Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Болд-д:

1. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах, Засаг даргын захирамжид хяналт тавих, тендерийн бичиг баримтыг холбогдох хууль, дүрэм журмын дагуу үдэж цэгцлэн архивын нэгж болгох.

Холбогдох байгууллагын санал:

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын тайлбар: Санал нэг байна гэж үзэв.	 ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ Танай ирүүлсэн “Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг, Засгийн газраас олгосон векселийн үр дүн” гүйцэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Цаашид зураг, төсөөгүй хийгдэж байгаа төсөл арга хэмжээг төсвийн төсөлд суулгахгүй байх, магадлашгүй ажлын бичиг баримтын бүрдлийг хангуулж, зөвлөмжийн хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулах тал дээр анхаарч ажиллах болно. БАРИЛГЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Б.ЭНХЖАРГАЛ D:\Documents \tool\ 08 568
Санал нэг байна гэж үзэв.	 АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг, гүйцэтгэлийн аудитын дүгнэлт, зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байна. Аудитын байгууллагын өгсөн үүрэг, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно. ДАРГА  Б.БОЛД

Уг саналыг хүлээн авах боломжгүй байна. /Тайланд тодорхой тусгасан/



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР**

67123, Мөрөн, Хөвсгөл аймаг
Утас: 70382216
www.khovsgol.gov.mn

2017.04.18 № 3/842
Тайлбар 2017.04.17-ийн № 9/407-т

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Аймгийн Аудитын газраас Хөвсгөл аймгийн орон нутгийн 2016 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх зардал бууруулах төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэхэд өгөх санал дүгнэлтэнд зураг төсөв, байхгүй гэж тусгагдаагүй байна. Дүгнэлтэд тусгагдсан ажлуудын зураг төсвийг Аудитын газрын дарга, Г.Оюунгэрэл, ИТХ-ын дарга асан Т.Болдбаатар нар байна гэж дүгнэж байсан.

Нэр бүхий 4-н байгууллагад тооцсон алдангийг Аудитор, шинжээч нар буруу тооцсон байсныг манай байгууллагын мэргэжилтнүүд залруулсан болно. Цагаан-Үүр сумын Тарвагатайн давааны зам засварын ажлын алданги 1636,0 мянган төгрөгийн тайлбарыг өмнө хүргүүлсэн бөгөөд хүснэгт 7-оос хасуулах саналтай байна.

ДАРГА



Х.ГАН-ОЧИР

03 0374

Хавсралт 2:

Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний судалгаа

/сая төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр	2016 оны ХО-ын хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө			Зураг, төсөв хийгдсэн эсэх	Гэрээний дүн	2016 онд санхүүжүүлсэн дүн	тайлбар тодруулга
		эхлэх	дуусах	Төсөвт өртөг				
Орон нутагт эрх шилжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалт								
1	Цагдаагийн кабон /Хөвсгөл Алаг-Эрдэнэ сум/	2016	2016		Тийм		-	Бүрэн хэрэгжсэн /Холбогдох баримт ЦЕГ авсан/
2	Цагдаагийн кабон /Хөвсгөл Цагаан-Үүр сум/	2016	2016		Тийм		-	Бүрэн хэрэгжсэн /Холбогдох баримт ЦЕГ авсан/
3	"Гурван гал" өрхийн эмнэлгийн их засвар /Хөвсгөл, Мөрөн/	2016	2016	280.0	Тийм	231.77	131.77	Гэрээний хугацаа сунгасан, ажил дуусаагүй.
4	Цэцэрлэгийн барилгын засвар /Хөвсгөл, Мөрөн сум, 6 дугаар цэцэрлэг/	2016	2016	120.0	Тийм	103.99	103.99	Бүрэн хэрэгжсэн
5	Цэцэрлэгийн барилгын засвар /Хөвсгөл, Мөрөн сум, 7 дугаар цэцэрлэг/	2016	2016	35.7	Тийм	35.0	35.0	Бүрэн хэрэгжсэн
6	Цэцэрлэгийн засвар /Хөвсгөл, Мөрөн сум, 4 дүгээр цэцэрлэг/	2016	2016	48.5	Тийм	48.12	48.12	Бүрэн хэрэгжсэн
7	Жаргалант сумын ЭМТ-д түргэн тусламжийн автомашин нийлүүлэх	2016	2016	29.0	-		-	Бүрэн хэрэгжсэн
8	Их-Уул сумын СДЭ-т түргэн тусламжийн автомашин нийлүүлэх	2016	2016	29.0	-	28.9	28.9	Бүрэн хэрэгжсэн
9	Агаар дахь тоосонцорыг хэмжих багаж хэрэгсэл, бусад тоноглол нийлүүлэх	2016	2016	130.0	-		-	Бүрэн хэрэгжсэн
10	Тоног төхөөрөмж нийлүүлэх	2016	2016	140.0	-	51.16	51.16	Бүрэн хэрэгжсэн
11	Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4 кв-н өргөтгөл, шинэчлэл	2014	2017	3600.0 1000.0	Тийм	3579.3 1322.2	1526.8 250.2	Зүүн Мөрөн хорооллын цахилгаан хангамж, Мөрөн сумын 10-р баг 0.4 кв-н ажлууд хийгдсэн.
	Нийт дүн							
Орон нутгийн хөрөнгө оруулалт								
1	Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн засвар, тохижилт	2016	2016	35.0	Тийм	34.25	31.81	Бүрэн хэрэгжсэн. Ашиглагч тал зарим өрөөний зориулалтыг өөрчилсөн

2	Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасагт амьсгалын аппарат авах	2016	2016	30.0	-	28.79	28.79	Бүрэн хэрэгжсэн
3	МСҮТ-ийн дотуур байрны агааржуулагчийн засвар	2016	2016	5.0	-	5.0	5.0	Бүрэн хэрэгжсэн
4	4-р цэцэрлэгийг төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлын дуусгалт	2016	2016	39.0	Тийм	39.0	39.0	Бүрэн хэрэгжсэн
5	Архивын тасагт шаардлагатай техник хэрэгсэл авах	2016	2016	60.0	-	36.9 15.33	36.9 15.33	Бүрэн хэрэгжсэн
6	Эрчим-1 ахмадын амралтын газрын 5 байрны дээврийн засвар	2016	2016	10.34	Тийм	9.0	8.85	Бүрэн хэрэгжсэн
7	Цагаан-Уул сумын гүний худгийн цахилгааны эх үүсвэр	2016	2016	15.0	Тийм	15.0	14.87	Бүрэн хэрэгжсэн
8	Гавъяат багш Д.Батсуурийн хөшөө, дурсгалыг сэргээн засварлах	2016	2016	4.0	Тийм	4.0	4.0	Бүрэн хэрэгжсэн
9	Цагаан-Үүр сумын эхчүүдийн амрах байрны тохижилт	2016	2016	1.0	-		0	Гэрээ хийгдээгүй, хэрэгжээгүй.
Нийт дүн				199.34		187.27	184.55	
Аймгийн замын сангийн хөрөнгөөр хийх төсөл, арга хэмжээ								
1	Цагаан-Үүр сумын Тарвагатайн давааны зам засвар	2016	2016	50.0	тийм	45.44	45.44	Бүрэн хэрэгжсэн
2	Бүрэнтогтох-Төмөрбулаг чиглэлийн Цагаанбургасын давааны зам засвар	2016	2016	180.0	тийм	165.6	164.16	Бүрэн хэрэгжсэн
3	Түнэл-Чандмань-Өндөр чиглэлийн Бор бургасын давааны зам засвар	2016	2016	90.0	тийм	81.73	74.54	Бүрэн хэрэгжсэн
4	Баянзүрх сумын Хянгараг, Улаан модны давааны зам засвар	2016	2016	15.0	тийм	14.96	0	Гүйцэтгэгч шалгарсан ч ажил нь хийгдээгүй.
5	Мөрөн сумын Сод-Эрдэм сургуулийн баруун талын 0.4 км хайрган хучилттай авто зам	2016	2016	18.25	тийм	18.0	17.55	Бүрэн хэрэгжсэн
6	“Зам талбай” арга хэмжээ зохион байгуулах	2016	2016	10.0	-	7.5	0.5	Бүрэн хэрэгжсэн
Нийт дүн				363.25		333.23	302.19	

Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

Нэг. Зөрчил

/сая төгрөг/

№	Зөрчлийн товч утга	Зөрчлийн дүн
1	Зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээг баталсан.	814.5
2	Ажил гүйцэтгэх гэрээний хугацаа хэтрүүлсний алдангийг тооцоогүй.	2.0
3	Магадлашгүй ажлын зардлыг актаар тогтоогоогүй олгосон.	6.4
	Нийт дүн	822.9

Нийт 822.9 сая төгрөгийн / Найман зуун хорин хоёр сая есөн зуун мянган төгрөг/ зөрчил илэрлээ.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2017 оны 4 сарын 10 өдөр

Дугаар А-9

Мөрөн

**Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулах
тухай**

Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 121, 2017 оны А/12 дугаар тушаал, Гүйцэтгэлийн шалгалтын журмын 23 дугаар зүйлийн 23.2, гүйцэтгэлийн аудитын тайлан хянан баталгаажуулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2 дах заалт заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг, Засгийн газраас олгосон векселийн үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, аймгийн Орон нутгийн өмчийн газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллан, үр дүнг 2017 оны 10 дугаар сарын 01-ний дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Л.Төмөрбаатар, аймгийн Засаг дарга Л.Ганболд, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргыг түр орлон гүйцэтгэгч Э.Аззаяа, аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Болд нарт зөвлөсүгэй.

4. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аудитын менежер /Г.Эрдэнэчимэг/, гүйцэтгэлийн аудитын ахлах аудитор /Ж.Отгончимэг/ нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ОЮУНГЭРЭЛ